ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 12 сарын 16 өдөр Дугаар 127 Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8.1 дүгээр зүйлийн 9.15 дахь заалт, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 10.[1] дүгээр зүйлийн 10.[1].2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Магадлан шалгах ажиллагааны дүгнэлтийн дагуу шуудангийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хуулийн этгээд (3)-ийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2.Тусгай зөвшөөрөл шинээр олгосон хуулийн этгээдтэй хуульд заасан хугацаанд гэрээ байгуулах, зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх арга хэмжээ авч ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД Б.АНХБААТАР

Ц.ГАНЗОРИГ

Б.ДАГВАСҮМБЭРЭЛ

Ч.ЗОЛБАЯР

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
127 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрөл олгосон хуулийн этгээдийн
жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Хамрах хүрээ, Үйлчилгээний хүртээмж	Тусгай зөвшөөр-лийн хугацаа	Дуусах хугацаа
1	“Алаг бугын эрдэнийн баялаг” ХХК	Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх	5 жил	2031.10.16
2	“Юбикаб экспресс” ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс-БНХАУ/	5 жил	2031.10.16
3	“Зибби транс” ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс-АНУ/	5 жил	2031.10.16

------ oOo --------